



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.07.08 № 01/1290

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичиг  
хянасан тухай**

Танай эмнэлгээс зарласан “Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” ЭМЯ/20240102089 дугаартай тендерийн баримт бичигт “Санчир ундрах” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

Тендерийн баримт бичгийн “Багц 1 Титэм судсан дотуурх хэт авиан оношилгооны аппаратын иж бүрдэл (Intravascular ultrasound imaging system-IVUS) /1 иж бүрдэл аппарат/” техникийн тодорхойлолтод 2.8 iFR modality Spot/Pullback гэж, 2.9 IFR scout modality гэж, 3.1 20МГц хүртэл импульстай гэж, 4.1 Pressure guide wire /2 горимд ашиглах боломжтой байх гэж тус тус заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т “Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно” гэж заасан байна.


Захиалагч тендерийн баримт бичгийн “Багц 1 Титэм судсан дотуурх хэт авиан оношилгооны аппаратын иж бүрдэл (Intravascular ultrasound imaging system-IVUS) /1 иж бүрдэл аппарат/-ын техникийн тодорхойлолтыг Philips брэндийн аппаратын онцлох үзүүлэлтэд нийцүүлж боловсруулан бусад аж ахуй эрхлэгчийн өрсөлдөх боломжийг хязгаарласан байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасныг зөрчсөн байна.

0002849

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2-т “Зөрчлийг арилган, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг даалгах” гэж заасны дагуу тендерийн баримт бичгийн “Багц 1” техникийн тодорхойлолтод холбогдох өөрчлөлтийг оруулж, хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.

ДАРГА



Б.БИЛГҮҮН